Мөнххайрхан сумын засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн төрийн үйлчилгээг ард иргэдэд чанартай ил тод, тэгш хүргэж ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, хувь хүмүүс өрх гэрүүдэд өөрийгөө тэтгэн хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, тэдний бие бялдар, сэтгэл зүйн сайн сайхан байдлыг хамгаалахад үйл ажиллагаагаа чиглүүлсэн байна. Тус сум нь 2020 оныг “Дэд бүтцийг сайжруулах, иргэдийн амьдрах таатай орчин бүрдүүлэх жил” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- *Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрчимжүүлж, байгаль орчин, бизнест ээлтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлэх*
- *Төрийн үйлчилгээг чанарын шинэ шатанд гаргаж, ард иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, аж амьдралыг дээшлүүлэх олон талт үйл ажиллагаа явуулах*

3.5 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Мөнххайрхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүү, дотоод аудитын албанаас 2020 онд сумын ТТЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж анхан шатны баримтын бүрдэл дутуу, кассын журам зөрчсөн, шатахуун илүү зарцуулсан, эм орлого аваагүй, хүүхдийн хоол илүү зарцуулсан, өвс тэжээл орлого аваагүй, зориулалт бус зарцуулсан, хугацаа хэтэрсэн зээлд алданги тооцоогүй зэрэг зөрчилтэй холбоотой 15645.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоогдож зөвлөмж өгөгдсөн байна.

Мөнххайрхан сумын ТТЗ-ын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй гэж үзлээ.

3.6 3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшнийг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Энэ нь материаллаг байдлыг үнэ цэнэ талаас нь авч үзэхийн тулд санхүүгийн тайлангийн хамгийн чухал хэсгүүд болох нийт орлогыг /өөрийн орлого, төсвийн санхүүжилт, татвар болон татварын бус орлого / сонгон авч үзлээ.

Төлөвлөлтийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаас тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нийт орлого 3494541.5 мянган төгрөгөөс 1 хувиар тооцож 34945.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 171414.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 65579.3 мянган төгрөг болж, 105835.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл		/мянган төгрөг/	
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сан	156,479.8	38,742.3	(117,737.5)
ОНХС	-	-	-
СХС	14,934.6	26,837.0	11,902.4
Нийт	171,414.4	65,579.3	(105,835.1)

Эх сурвалж: Мөнххайрхан сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайла

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 65579.3 мянган төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байгаа бөгөөд арилжааны банканд харилцах данс байхгүй байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 327094.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 303037.0 мянган төгрөг болж 24057.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №.2. Авлагын үлдэгдэл		/мянган төгрөг/	
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	374.5	521.1	146.6
Байгууллагаас авах авлага	367.1	-	(367.1)
Хувь хүмүүсээс авах авлага	4.0	-	(4.0)
Урьдчилж гарсан зардлын авлага	136,529.5	112,219.9	(24,309.6)
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	189,819.0	190,296.0	477.0
Дүн	327,094.1	303,037.0	(24,057.1)

Эх сурвалж: Мөнххайрхан сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай сум хөгжүүлэх сангийн 128105.8 мянган төгрөг, хугацаандаа байгаа болон бусад 62190.2 мянган төгрөгийн авлага, урьдчилж гарсан зардлын авлага 112219.9 мянган төгрөг, бусад 521.1 мянган төгрөгийн авлагууд байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага оны эхэнд 189819.0 мянган төгрөг оны эцэст 190296.0 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 29000.0 мянган төгрөгийн зээл олгож, 34352.9 мянган төгрөгийн зээл, зээлийн хүү эргэн төлөгдөж, оны эцэст 26837.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Сум хөгжүүлэх сангаас 2017-2019 онуудад олгосон 22 иргэний 35365.7 мянган төгрөгийн зээлийн авлага нь хэвийн төлөгдөж, 2011-2016 онуудад олгосон 60 иргэнтэй холбогдох 145005.9 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага сангийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна. Тухайн хугацаа хэтэрсэн 60 иргэнээс 8 иргэнтэй холбогдох 12287.6 мянган төгрөгийн авлагыг 2020 оны 1 дүгээр сард шүүх, хяналтын байгууллагад шилжүүлсэн байна. СХС-ийн 4612.5 мянган төгрөгийн зээлтэй 3 иргэн нас барсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Малжуулах зээлийн эргэн төлөлтийн тооцоо хийгээгүй, зээлдэгч иргэдийн хувийн хэргийн зээлийн мэдээлэл байхгүй байгаа 49920.0 мянган төгрөг, урьдчилж гарсан зардлын тооцоо хийж баталгаажуулаагүй, насжилт өндөртэй авлага бууруулаагүй 10400.0 мянган төгрөг,
- ЕБС-ийн хөл бөмбөгийн талбайн мөнгө урьдчилж олгоод гүйцэтгэгч байгууллагатай тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, тоолуурын багцлалын урьдчилж гарсан зардлын одоог хүртэл хийгээгүй 50000.0 мянган төгрөг,
- ЭМТ-ийн тавилга хугацаандаа нийлүүлээгүйгээс урьдчилж гарсан зардлаар бүртгэж тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй 1899.9 мянган төгрөг,
- Сум хөгжүүлэх сангаас 2016 оос өмнө олгосон 49 иргэнтэй холбогдох 128105.8 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага сангийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

3.7 3.5.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 187667.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 216414.0 мянган төгрөг болж, 28746.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 3. Бараа материалын үлдэгдэл		/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	
Эм боох материал	6,532.4	20,030.5	13,498.1	
Бэлэн бүтээгдхүүн	9,480.5	9,172.5	(308.0)	
Бичиг хэргийн материал	4,246.6	3,339.7	(906.9)	
Аж ахуйн материал	20,818.9	29,510.3	8,691.4	
Сэлбэг хэрэгсэл	271.0	271.0	-	
Түлш, шатах тослох материал	17,362.7	11,113.1	(6,249.6)	
Барилгын засварын материал	2,747.2	3,716.1	968.9	
Хүнсний материал	19,830.5	19,573.0	(257.5)	
Бусад хангамжийн материал	106,377.4	119,687.8	13,310.4	
Дүн	187,667.2	216,414.0	28,746.8	

Эх сурвалж: Мөнххайрхан сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын бараа материалын үлдэгдэл 28746.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд эм, ариутгалын бодис болон ажилчдын нормын хувцас, хүнс нөөцөлж авсан байгаа нь нөлөөлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Сумын сургуулийн хүүхдийн хоолны мөнгө тушаал шийдвэргүй зарлагдсан, хүнсний материалын тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй, балансын үлдэгдэл, нярвын тайлангийн үлдэгдэл зөрүүтэй байгаа 11692.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Дээрх алдаа зөрчлийг төсвийн шууд захирагч нарын тайланд тусган шийдвэрлэснийг Төсвийн төвлөрүүлэн захирагч дотоод хяналт хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4816189.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 5531808.7 мянган төгрөг болж, 715619.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл		/мянган төгрөг/	
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бүүралт (-)
Барилга байгууламж, орон сууц	2,919,190.9	3,060,390.9	141,200.0
Тээврийн хэрэгсэл	221,543.4	300,993.5	79,450.1
Машин тоног төхөөрөмж	592,196.4	683,825.1	91,628.7
Тавилга эд хогшил	236,036.6	252,204.6	16,168.0
Зам гүүрийн байгууламж	353,545.0	660,444.0	306,899.0
Дуусаагүй барилга байгууламж	-	-	-
Номын фонд	42,176.6	50,394.7	8,218.1
Бусад үндсэн хөрөнгө	313,979.5	387,224.9	73,245.4
Программ хангамж	4,310.0	3,120.0	(1,190.0)
Бусад биет бус хөрөнгө	133,211.0	133,211.0	-
Дүн	4,816,189.4	5,531,808.7	715,619.3

Эх сурвалж: Мөнххайрхан сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 11280.1 мянган төгрөг, балансаас баланст шилжүүлэн авсан 2250.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй авсан 717901.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн, хандивын хөрөнгөөр 17122.0 мянган төгрөг, акталсан 32714,1 мянган төгрөгөөр шилжүүлсэн хөрөнгө 220.2 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Засаг даргын Тамгын газар болон төсөвт байгууллагууд тайлант онд үндсэн хөрөнгийн бүртгэлд тавих хяналт сул, үнэ төлбөргүй авах хөрөнгийн орлогыг үр дүнд буруу тайлагнасан, засгийн газрын 10-р тогтоолын хэрэгжилт хангалтгүй, ТШЗ-ийн тайланд үнэ төлбөргүй хөрөнгө дутуу авсан 2680533.3 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 12719.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 2435.8 мянган төгрөг болж 10283.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/				
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн				
Ажилчидтай холбогдсон өглөг	495.3	1,687.0	1,191.7	29.4
Хувь хүнд төлөх өглөг	5,734.6		(5,734.6)	
Дансны өглөг /ОНӨААТҮГ/			-	
Байгууллагад төлөх өглөг/ ОНӨААТҮГ/	6,063.7		(6,063.7)	
Бараа үйлчилгээний зардлын өглөг			-	
Байгууллагад төлөх өглөг	425.6	748.8	323.2	56.8
Нийт дүн	12,719.2	2,435.8	(10,283.4)	86.2
<i>Эх сурвалж: Мөнххайрхан сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайл</i>				

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 2435.8 мянган төгрөгийн өр байна. Өндөр дүнтэй өглөгийг барагдуулсан, бага дүнтэй өглөгүүд дараа тайлангийн хугацаанд бүрэн барагдах боломжтой өглөгүүд байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 8339447.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 9076450.8 мянган төгрөг болж 737003.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт+/, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,169,724.0	4,538,225.4	368,501.4
Засгийн газрын оруулсан капитал	2,353,380.1	2,353,488.9	108.8
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/			-
Хуримтлагдсан үр дүн	520,230.4	889,004.6	368,774.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,296,113.2	1,295,731.9	(381.3)
Дүн	8,339,447.7	9,076,450.8	737,003.1
<i>Эх сурвалж: Мөнххайрхан сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан</i>			

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 1295731.9 мянган төгрөг болж 381.3 төгрөгөөр буурсан нь төсөвт байгууллагуудын дахин үнэлгээтэй хөрөнгө акталсантай холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүн 889004.6 мянган төгрөг болж 368774.2 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаар бий болсон, дээд шатны байгууллагаас үнэ төлбөргүйгээр хүлээн авсан хөрөнгийн бүртгэлтэй холбоотой байна.

3.5.10 Орлогын данс

Өмнөх оны үзүүлэлтээс орлого үр дүн материаллаг өөрчлөлт гарсан 238728.9 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант оны орлогын үзүүлэлт татварын орлого 20358.2 мянган төгрөг, 164244.1 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй орлого, 54126.6 мянган төгрөгөөр нэмэлт санхүүжилтийн орлого нэмэгдсэнтэй холбоотой болно.

Аудитын илрүүлэлт:

- ИТХ-ын санхүүжилт илүү олгосон, төрийн сангийн дотоод хяналт хангалттай хэрэгжүүлээгүй 505.4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

-Үйл ажиллагааны орлого дутуу төвлөрүүлсэн, сумдын байцаагч нарын гүйцэтгэлийн ажлын тайлан хангалтгүй, мэдээлэл өгдөггүй, татварын орлогын төлөвлөлт гүйцэтгэлд тулгуурлаагүй, газрын төлбөрийн орлогын мэдээлэл хангалтгүй, бүртгэл тооцоо судалгаа ирүүлээгүй 776.0 мянган төгрөгийн зөрчил байна.

3.5. Зардлын данс

Нийт зардал өмнөх оноос 96027.1 мянган төгрөгөөр буурсан байна. Төсөвт зөрдлөөс тогтмол зардал 3147.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 45883.3 мянган төгрөгөөр, 46996.3 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 2034.0 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Зардлын данстай холбоотой 54079.2 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бус, үрэлгэн зарцуулсан зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, ихэнх ажлууд хүлээн авсан актгүй, явцын хяналт хийгдээгүй, ажлын гүйцэтгэлийн тайлан байхгүй, е баримтгүй гүйлгээ хийсэн, урсгал зардалд зарцуулсан, чиг үүргийн байгууллагаас өөр байгууллагын хөрөнгө санхүүжүүлсэн 53089.2 мянган төгрөг,
- ОНХС-ийн хөрөнгөөс хүлээн авалтын зардал гарган зориулалт бус зарцуулж журам зөрчсөн, хуулийн хэрэгжилт хангалтгүй 990.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Мөнххайрхан сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 10/02 дугаар тогтоолд Мөнххайрхан сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 35366.5 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 55724.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 135 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт дугаар №7 Орлогын төлөвлөгөө гүйцэтгэл		/мянган төгрөгөөр/			
д/д	Орлогын нэр төрөл	Орон нутгийн татварын орлого	2020.09.28/10/02 тоот тогтоолоор	Орлогын гүйцэтгэл	Зөрүү
	Нийт орлогын дүн	41,466.9	35,366.5	55,724.70	(20,358.2)
А	Нийт орлого тусламжийн дүн	41,466.9	35,366.5	55,724.70	(20,358.2)
Б	Нийт орлогын дүн	41,466.9	35,366.5	55,724.70	(20,358.2)
В	Суурь орлогын дүн	41,466.9	35,366.5	55,724.70	(20,358.2)
	Урсгал орлогын дүн	28,439.4	35,366.5	55,724.70	(20,358.2)
Г	Татварын орлого	28,439.4	33,366.5	54,024.70	(20,658.2)
1	Хувь хүний орлогын албан татвар	23,925.0	23,925.0	41,496.00	(17,571.0)
	Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын АТ				-
	Үйл ажиллагааны орлогын татвар	8,925.0	8,925.0	20,101.60	(11,176.6)
	ОТБТБАУ-ний орлогын албан татвар				-
	Хөрөнгийн орлого	14,000.0	14,000.0	16,487.10	(2,487.1)
	ХХОАТ-ын бусад орлого	1,000.0	1,000.0	4,907.30	(3,907.3)
	ХХОАТ-ын буцаан олголт				-
2	Өмчийн татвар	4,514.4	4,514.0	6,997.50	(2,483.5)
	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар			1,754.80	(1,754.8)
	Бууны албан татвар	4,514.4	4,514.0	4,872.00	(358.0)
	Иргэний эрх борлуулсан орлого	-		370.70	(370.7)
	Дотоодын бүтээгдэхүүн үйлчилгээний татвар	-	-	-	-
	Авто хэрэгсэлийн татвар				-
4	Бусад орлого	13,027.5	4,927.5	5,531.20	(603.7)
	Улсын тэмдэгтийн хураамж	2,450.0	2,450.0	759.40	1,690.6
	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	710.0	710.0	2,038.60	(1,328.6)
	Ан амьтан агнах зөвшөөрлийн хураамж	8,100.0	-		-
	Ус рашааны нөөц ашигласны төлбөр	267.5	267.5	309.70	(42.2)
	Газрын төлбөр			352.20	(352.2)
	Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт				-
	Ойн нөөц ашигласны төрбөр				-
	Байгалийн ургамалын нөөц ашигласны төлбөр	1,200.0	1,200.0	1,609.50	(409.5)
	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	300.0	300.0	461.80	(161.8)
	Татварын хүү торгууль				-
Д	Татварын бус орлого	-	2,000.0	1,700.0	300.0
	Татварын алданги орлого				-
	Хүү торгуулийн орлого		2,000.0	1,700.0	300.0

Эх сурвалж: Мөнххайрхан сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2367276.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2367276.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 2207430.3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2049334.6 мянган төгрөгийг урсгал зардалд, 106431.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд 51664.2 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1433947.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 697405.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 22407.7 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 53669.2 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлого, 106431.5 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөж санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Хүснэгт №.8. Санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Мөнгөн хөрөнгийн		ЭХ ҮҮСВЭР						Хэмнэлт хэтрэлт	Тайлбар
	C1	C2	Нийт төлөвлөгөө			Эх үүсвэрийн гүйцэтгэл				
			Санхүүжилт	Өөрийн орлого	нийт	Санхүүжилт	өөрийн орлого	Нийт		
ЗДТГ	-	-	439,009.0	605.0	439,614.0	439,009.0	605.0	439,614.0	-	
ИТХ	-	-	52,258.4	-	52,258.4	52,763.8	-	52,763.8	505.4	ИТХ-д илүү санхүүжилт олгосон
СХС	14,934.6	26,837.0	51,664.2		51,664.2	44,498.9		44,498.9	(7,165.3)	СХС-ийн зээлийн эргэн төлөлт дутуу төвлөрсөн
ОНХС			62,909.5	-	62,909.5	62,909.5	-	62,909.5	-	
ОНБ дүн	14,934.6	26,837.0	605,841.1	605.0	606,446.1	599,181.2	605.0	599,786.2	(6,659.9)	
ЕБСургууль	-	-	847,194.8	400.0	847,594.8	847,194.8	400.0	847,594.8	-	
Хүүхдийн цэцэрлэг	-	-	264,394.3		264,394.3	264,394.3		264,394.3	-	
ЭМГ	-	-	402,935.9	-	402,935.9	402,926.5		402,926.5	(9.4)	
Соёлын төв	-	-	85,059.2	1,000.0	86,059.2	85,059.2	224.0	85,283.2	(776.0)	Орлого бүрэн төвлөрүүлээгүй
ТЗШ дүн	-	-	1,599,584.2	1,400.0	1,600,984.2	1,599,574.8	624.0	1,600,198.8	(785.4)	
Нийт	14,934.6	26,837.0	2,205,425.3	2,005.0	2,207,430.3	2,198,756.0	1,229.0	2,199,985.0	(7,445.3)	

Эх сурвалж: Мөнххайрхан сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн үйл ажиллагааны орлого 2005.0 мянган төгрөг бүрдүүлэхээр батлагдсан байна. Тайлант онд 1229.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж батлагдсан төсвөөс 776.0 мянган төгрөгөөр буурсан нь Соёлын төвийн үйл ажиллагааны орлого ковидын хөл хорио тогтоож үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотой байна. ИТХ-ын санхүүжилт илүү олгож олгосон санхүүжилт ерөнхий орлогод төвлөрсөн байна. Эрүүл мэндийн даатгалаас 9.4 мянган төгрөг дутуу санхүүжсэн байна.

Туслах үйл ажиллагааны орлого 44498.9 мянган төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 7165.3 мянган төгрөгөөр буурсан нь СХС-гийн зээлийн эргэн төлөлтөөс оруулах орлого биелээгүйтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын 10 төсөл, арга хэмжээнд 62909,5 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 62909.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож орон нутгийн хөгжлийн сангийн дансанд үлдэгдэлгүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл нь 2199985.0 мянган төгрөг зарцуулагдаж нийт зардал 98.0 хувьтай байгаа нь хөрөнгийн зардалтай холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар ХХҮХ-ээс ахмадын өдөрлөгт 2000.0 мянган төгрөг, тендерийн хураамж 350.0 мянган төгрөг, ДБХ сангаас бэлчээр хамгаалах 8924.4 мянган төгрөг, мал тооллогын зардал 3349.6 мянган төгрөг, үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос 3517.0 мянган төгрөг, АОНХС-аас цэцэрлэгийн их засварын хөрөнгө оруулалт 104100.5 мянган төгрөг, ЕБС-д номын түрээсийн орлого 2460.0 мянган төгрөг, АОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хөл бөмбөгийн талбайн санхүүжилт 50000.0 мянган төгрөг, түрээсийн орлогоос 2496.0 мянган төгрөг, ЭМГ-аас сорьц тээвэрлэх зардал 59.7 мянган төгрөг, эмийн үнэ 10082.5 мянган төгрөгийн орлого, нийт 187340 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Хүснэгт №.9. Нэмэлт данс

/мянган төгрөг/

		Бусад орлого	Нийт	
1	ЗДТГ	18141.0	18141.0	ОНХС хөрөнгө оруулалт, хүн амын тооллогын зардал, бэлчээр ашиглалтын хөрөнгө оруулалт
2	ЕБС	54956.0	54956.0	төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого, хөл бөмбөгийн талбайн хөрөнгө оруулалт
3	ЭМТ	10142.5	10142.5	ЭМГ -аас эм бэлдмэлийн үнэ, сорьц тээврийн ажлын хөлс
4	Цэцэрлэг	104100.5	104100.5	ОНХС-аас их засварын зардал
Нийт дүн		187340.0	187340.0	

Эх сурвалж: Мөнххайрхан сумын ТТЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үүнээс ахмадын өдөрлөгт 2000.0 мянган төгрөг, бичиг зардалд 350.0 мянган төгрөг, бэлчээр хамгаалж тор татсан 8924.4 мянган төгрөг, мал тооллогын зардал 3349.6 мянган төгрөг, цэцэрлэгийн барилгын их засварт 104100.5 мянган төгрөг, номын түрээсийн орлогыг БСУГ-т 2460.0 мянган төгрөг, хөл бөмбөгийн талбайн санхүүжилтийг он дамжуулан хийхээр урьдчилж гарсан зардлаар 50000.0 мянган төгрөг авлагаар тусгасан, сан техникийн засварт 2496.0 мянган төгрөг, сорьц тээвэрлэх зардалд 59.7 мянган төгрөг, өмнөх оны эмийн өр төлж 10082.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 158 мэдээллээс 9 мэдээлэл хугацаа хоцроож 149 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 983.3 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд төлбөрийн акт, 76209.4 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд албан шаардлага, 80000.0 мянган төгрөгийн 3 алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт 100% хэрэгжсэн байна.

Хүснэгт 10 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	983.3	1	983.3			100
Албан шаардлага	2	76209.4	2	76209.4			100 %
Зөвлөмж	3	80000.0	3	80000.0			100%
Нийт	6	157192.7	6	157192.7			100%

Өмнөх онд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 4 тайланг түүвэрт хамруулсан байна.

Хүснэгт №11. Аудитад хамрагдсан хэлбэр, аудитын дүгнэлт

№	Байгууллагын ангилал, нэр	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр		Аудитын дүгнэлт		
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг
1		ЗДТГ		1		
2		ИТХ		1		
3	Төсвийн шууд захирагч	Сургууль	1			1
4		Цэцэрлэг	1		1	
5		ЭМТ	1		1	
6		Соёлын төв	1		1	
7	ОНТС	СХС		1		
8		ОНХС		1		
Дүн			4	4	3	1

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-3, “Хязгаарлалттай”-1 нийт 4 дүгнэлт гаргасан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа, зөрчил:

Аудитаар нийт 2976219.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 232105.0 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил арилгах 1 албан шаардлага, 2744114.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, хөрөнгө шийдвэрлэх 3 зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдээгүй болно.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага:

Аудитаар дараах 232105.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд албан шаардлага тогтоож хүргүүллээ. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө

- 1.1. *Илрүүлэлт: ОНХС-ийн хөрөнгөөс хүлээн авалтын зардал гарган зориулалт бус зарцуулж журам зөрчсөн, хуулийн хэрэгжилт хангалтгүй, төсвийн хөрөнгийн үр ашгийг бууруулсан 990.0 мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ.*

Энэ нь Төрийн Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 6-р зүйлийн 6.4.2-д "төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", ОНХС-ийн 228-р журмын 4-р зүйлийн 4.2.4-д "аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал"-д зарцуулахыг хориглоно" гэсэн хуулийн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв, байх батламж мэдээдлийг хангахгүй байна.

- 1.2. *Шийдвэрлэсэн нь: Сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байгаа 990.0 мянган төгрөгийн албан шаардлага бичих*

2. ОНХС, СХС-ийн зарцуулалт

- 2.1. *Илрүүлэлт: ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, ихэнх ажлууд хүлээн авсан актгүй, явцын хяналт хийгдээгүй, ажлын гүйцэтгэлийн тайлан байхгүй, ө баримтгүй гүйлгээ хийсэн, урсгал зардалд зарцуулсан, чиг үүргийн байгууллагаас өөр байгууллагын хөрөнгө санхүүжүүлсэн 53089.2 мянган төгрөг,*

- *Илрүүлэлт: СХС-ийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй, хийж хэрэжүүлсэн ажлын тайлан байхгүй, зориулалтын дагуу ашиглахгүй байгаа зээлтэй, зээл олгосон зээлийн гэрээ гарын үсгээр баталгаажуулаагүй, хувийн хэргийн баримтын бүрдэл хангалтгүй 128105.8 мянган төгрөг,*
- *Илрүүлэлт: Урьдчилж гарсан зардлыг тооцоо актаар баталгаажуулаагүй, өмнөх оны урьдчилж гарсан зардлын тооцоог хөрөнгө орлого авч бууруулсан боловч ашиглагдаад олон жил болсон тухайн хөрөнгийн эдийн засгийн үр өгөөжийн үнэлгээ хийгээгүй, малжуулах зээлийн эргэн төлөлтийн тооцоо хувийн хэргийн зээлийн мэдээлэл байхгүй 49920.0 мянган төгрөг,*

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсэхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв, байх батламж мэдээдлийг хангахгүй байна.

2.2. Шийдвэрлэсэн нь: Зээлийн эргэн төлөлтийн үр дүнг дээшлүүлж төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах албан шаардлага бичих

Төвлөрүүлсэн захирагчид 2744114.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн алдаа, зөрчил

Мөнххайрхан сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 176921.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч 134425.3 мянган төгрөгийн 3 алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 42495.6 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс 690.3 мянган төгрөгийн 2 алдаа зөрчилд 2 төлбөрийн акт, 41805.6 мянган төгрөгийн 10 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 12. ТШЗ-ын нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт алдаа зөрчил, шийдвэрлэлт /мянган.төгрөг/

№	Байгууллагын нэр	нийт илэрсэн алдаа зөрчил		Үүнээс залруулсан		Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт			
								Төлбөрийн акт		Зөвлөмж	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Сургууль	6	45,474.9	1	5,745.2	5	39,729.3	1	396.3	4	39,333.3
2	Цэцэрлэг	5	119,368.9	1	116,896.6	4	2,472.3			4	2,472.3
3	ЭМТ	2	294.0			2	294.0	1	294.0	1	-
4	Соёлын төв	2	11,783.5	1	11,783.5	1	-	-	-	1	-
		15	176,921.3	3	134,425.3	12	42,495.6	2	690.3	10	41,805.6

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа хөрөнгө үзэх шаардлагатай гэж үзлээ.

3.8 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд 2744114.5 мянган төгрөгийн зөрчлийг цаашид анхаарвал зохих асуудлын тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: ИТХ-ын санхүүжилт илүү олгосон, төрийн сангийн дотоод хяналт хангалттай хэрэгжүүлээгүй 505.3 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого дутуу төвлөрүүлсэн, сумдын байцаагч нарын гүйцэтгэлийн ажлын тайлан хангалтгүй, мэдээлэл өгдөггүй, татварын орлогын төлөвлөлт гүйцэтгэлд тулгуурлаагүй, газрын төлбөрийн орлогын мэдээлэл хангалтгүй, бүртгэл тооцоо судалгаа ирүүлээгүй 776.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, төсвийн орлого бүрдэхгүй байх, дотоод хяналт хэрэгжихгүй байх

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 41-р зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17-р зүйлийн 17.1.2-д "холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хянах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, байцаагч нарын ажлын үр дүнг дээшлүүлэх, төсвийн орлого бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Урьдчилж гарсан зардалтай холбоотой

2.1. Илрүүлэлт: Урьдчилж гарсан зардлыг тооцоо актаар баталгаажуулаагүй, өмнөх оны урьдчилж гарсан зардлын тооцоог хөрөнгө орлого авч бууруулсан боловч ашиглагдаад олон жил болсон тухайн хөрөнгийн эдийн засгийн үр өгөөжийн үнэлгээ хийгээгүй, малжуулах зээлийн эргэн төлөлтийн тооцоо хувийн хэргийн зээлийн мэдээлэл байхгүй 62299.9 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

2.2. Эрсдэл: Сангийн хөрөнгийн үр дүн буурах, бусдад тэгш байдлыг олгохгүй байх, холбогдох хууль дүрэм журам хэрэгжихгүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж: Засгийн газрын 311 дүгээр тогтоолын 1.5-д "энэ журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө", 3.5-д "дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь хяналтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд 1 доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ", 3.6-д "дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах, малжуулах зээлийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн бүртгэлд тавих хяналт сул, үнэ төлбөргүй авах хөрөнгийн орлогыг үр дүнд буруу тайлагнасан, засгийн газрын 10-р тогтоолын хэрэгжилт хангалтгүй, төсвийн харьяа байгууллагууд санхүүгийн тайланд хөрөнгө

оруулалтаар хэрэгжсэн үнэ төлбөргүй хөрөнгө орлого дутуу авсан 2680533.3 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

3.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр дүн буурах, төсвийн хөрөнгө эзэнгүйдэх, хяналт буурах, дотоод хяналт хэрэгжихгүй байх

3.3 Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах, Засгийн газрын 10-р тогтоолын хэрэгжүүлэх, хөрөнгийн бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах, орлого аваагүй хөрөнгийн асуудал шийдвэрлэх

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 15-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Мөнххайрхан сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан	Аудитын код:
2020			ХОА-2021/6/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Мөнххайрхан сумын Засаг дарга		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Зээлийн эргэн төлөлт хангалтгүй, анхан шатны баримт дутуу, гарын үсгээр баталгаажуулаагүй зээл олгосон, малжуулах зээлийн тооцоо байхгүй, сангийн хөрөнгийн зарцуулалт хангалтгүй, сангийн хөрөнгө зориулалт бус зарцуулсан	232105.0	Албан шаардлага	Засаг дарга, Санхүү албаны дарга, Нягтлан бодогч	Б.Батболд Э.Эрэндаваа, А.Бат-Эрдэнэ
2	Үйл ажиллагааны орлого дутуу төвлөрүүлсэн, сумдын байцаагч нарын гүйцэтгэлийн ажлын тайлан хангалтгүй, мэдээлэл	1281.3	Зөвлөмж	Засаг дарга, Санхүү албаны дарга, Нягтлан бодогч	Б.Батболд Э.Эрэндаваа, А.Бат-Эрдэнэ

	өгдөггүй, татварын орлогын төлөвлөлт гүйцэтгэлд тулгуурлаагүй, газрын төлбөрийн орлогын мэдээлэл хангалтгүй, бүртгэл тооцоо судалгаа ирүүлээгүй				
3	Үндсэн хөрөнгийн бүртгэлд тавих хяналт сул, үнэ төлбөргүй авах хөрөнгийн орлогыг үр дүнд буруу тайлагнасан, засгийн газрын 10-р тогтоолын хэрэгжилт хангалтгүй, ТШЗ-ийн тайланд үнэ төлбөргүй хөрөнгө дутуу авсан байна.	2680533.3	Зөвлөмж	Засаг дарга, Санхүү албаны дарга, Нягтлан бодогч	Б.Батболд Э.Эрэндаваа, А.Бат-Эрдэнэ
4	Урьдчилж гарсан зардлыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, малжуулах зээлийн эргэн төлөлтийн тооцоо хувийн хэргийн зээлийн мэдээлэл байхгүй байна.	62299.9	Зөвлөмж	Засаг дарга, Санхүү албаны дарга, Нягтлан бодогч	Б.Батболд Э.Эрэндаваа, А.Бат-Эрдэнэ
	Дүн	2976219.5			

ХОВД АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР